

“МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАН

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тандан судалгаа хийв.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг зохицуулах харилцаа нь Хууль тогтоомжийн¹ хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах /цаашид “урьдчилан тандан судлах” гэх/ аргачлалын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг тус Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

1.1. Асуудлын хамрах хүрээ

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн талаар судалгаа шинжилгээг хийсэн. Мөн Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан иргэдээс гаргасан санал, хүсэлт зэргийг судалж энэхүү судалгааг хийсэн болно.

Эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2.-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх...”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Зорилт 3.1.Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхуйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.” мөн 3.1.1.“Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ.” 3.1.3.“Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Үүний дагуу Улсын Их хурлаас үүнтэй уялдуулан 2024 онд энэхүү хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

¹Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

№	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлэг	Тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж байгаа талаар
1	Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиар З дугаар зүйлийн 3.1.1-т “малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг	Нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс хамаарч нийгмийн даатгал төлөлт хожимдуулан төлөх боломжгүй болсны улмаас Монгол улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” хөндөгдөж байна

Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг нь малчин өрх, малчин, туслах малчин байхаар байна. Манай улсад нийт малчин өрхийн 96.5% нь үндсэн малчин, 3.5% хувь нь туслах малчин байна.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Тандан судлах ажлыг Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын хувьд нийгэм, эдийн засаг, цар тахлын онцгой нөхцөл болон байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал гэх зэрэг шалтгааны улмаас зорилтод бүлэг бүрэн хамрагдах боломжгүй болсон шалтгааны хүрээнд судаллаа.

Манай улсын малтай өрхийн тоо 2022 онд 248,3 мянга болж өсчээ. Жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрхийн тоо 190.8 мянга буюу малтай өрхийн 76.8 хувийг эзэлж байгаа бол малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үргүүлж буй өрх 23.1 хувийг бүрдүүлж байна. Малчин өрхийн тоо 2022 онд өмнөх оноос 2.2 мянга буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.Малчин өрх ба малчны тоо²

	2010 он	2015 он	2020 он	2021 он	2022 он
Малтай өрхийн тоо	216,570	216,734	242,024	246,302	248,296
Малчин өрхийн тоо	160,265	153,085	181,051	188,605	190,776
Малчны тоо	327,154	297,828	298,789	305,430	305,079


2022 оны байдлаар нийт малчдын дунд 15-44 хүртэлх насны малчид 26.9 хувь, 35-44 хүртэлх насны малчид 58.5 хувь, 55-аас дээш насны малчид 14.6 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн 3 жилд 15-34 насны залуу малчдын тоо 2.9 нэгж хувиар буюу 7.0

² УСХ мэдээ, 2022 он

мянгаар багасаж, 35-59 насын малчдын эзлэх жин 1.7 нэгж хувиар буюу 8.8 мянгаар нэмэгдсэн байна.

2022 оны байдлаар нийт малчдын дунд 15-44 хүртэлх насын малчид 26.9 хувь, 35-44 хүртэлх насын малчид 58.5 хувь, 55-аас дээш насын малчид 14.6 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн 3 жилд 15-34 насын залуу малчдын тоо 2.9 нэгж хувиар буюу 7.0 мянгаар багасаж, 35-59 насын малчдын эзлэх жин 1.7 нэгж хувиар буюу 8.8 мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 1.Малчдын насын бүтцийн өөрчлөлт, хувиар³



15-34 насын малчид 2010 онд нийт малчдын 43.5 хувийг эзэлж байсан бол 2022 онд 26.9 хувь болж 16.6 пунктээр буурч, 35-55 насын малчид мөн хугацаанд 15 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2021 онд өөрчлөлт оруулж 2022 оны 01 дүгээр 01-ний өдөр хүртэл хугацааг сунгасан. Гэвч хуулийн зорилтод бүлэг бүрэн хамрагдах боломжгүй байсан. Уг шалтгаанд дараах нөхцөл байдал нөлөөлсөн. Үүнд:

- Цар тахлын нөлөөлөл буураагүй бөгөөд түүний үр дагаврыг арилах хүртэл Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2022 оны 12 дугаар 31-ний хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. Үүнтэй уялдуулан төрийн байгууллагын зүгээс тодорхой хязгаарлалтууд тогтоож хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл үргэлжилсэн.
- Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны дөрийн А/71 тоот тушаалаар баталсан “Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу гарсан үзүүлэлтээр авч үзвэл. Хэрэглээний үнийн улсын индексийн үзүүлэлтээр инфляцын түвшин 2020 онд 2.3 хувь, 2021 онд 13.8 хувь, 2022 онд 13.2 хувь байсан бөгөөд инфляцын түвшин буураагүй.
- Малын зүй бус хорогдлын хувьд Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 07 -ны өдрийн А/188 тоот тушаалын I хавсралт “Хөдөө аж ахуйн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу хийгдсэн

³ УСХ мэдээ, 2022 он

судалгаанаас авч үзвэл. 2019 онд 1,117.58 толгой мал, 2022 онд 2,064.07 толгой мал, 2022 онд 3,012.33 толгой мал тус тус хорогдсон байна.

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны⁴ дүгнэлтээр манай улсын малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадавхын дундаж түвшин 40.45 индекс оноотой байна. Эрсдэл даах чадвар муу өрхүүд хөрөнгө, боломж хязгаарлагдмал тул өвлийн бэлтгэлээ сайн базаах чадамжгүй, нэг удаагийн байгалийн цочир үзэгдэлд малаа алдаж, ядуурлын доод шугам руу буух эрсдэлтэй байна. Судалгаанд хамрагдсан 21 аймгийн 330 сумын 10,023 малчин өрхийн амьжираанд сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн их нөлөөлсөн цочрол нь Ковид-19 цар тахал (75.6 хувь), дараа нь ган/зуд (48 хувь), энэ хоёр цочролоос үүдэлтэй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, өвс тэжээлийн үнийн хэлбэлзэл (37.2 хувь) байжээ.

Иймээс судалгааны дүнг үндэслэж, Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд, практик дээр дурдсан бэрхшээлүүдэд тулгуурлаж хуулийн төсөл боловсруулах зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго

2.1. Гол зорилго, зорилт

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт:

1. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлагыг тогтоох.
2. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөлд зохицуулалтыг тусгах.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар малчны тэтгэврийн даатгалд хамрагдаагүй малчин тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх боломж бүрдэх бөгөөд ингэснээр тэтгэвэр тогтоолгох боломж бололцоо бүрдэнэ. Тэтгэвэр бүр тогтоогдсон малчны хувьд Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх хангагдахаас гадна тухайн малчин өрхийн эдийн засгийн хувьд эерэг нөлөөлөл үзүүлэх юм.

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу “зорилгод хүрэх байдал” буюу

⁴ Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын судалгаа

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах замаар нийгэм дээрх бэрхшээлийг арилгах зорилгоор шийдлийг сонгх хувилбарыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус заасны дагуу Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Асуудалд дүн шинжилгээ хийх явцад хуулийг өөрчлөлт оруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гарцуудын талаар тодорхой судалгаанууд хийгдсэн.

- “Тэг” хувилбар буюу өөрчлөлт оруулахаас татгалзах. Энэ тохиолдолд өнөөгийн мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх боломжгүй бөгөөд энэ нь тэтгэвэрт гарах насны иргэдэд шууд сөргөөр нөлөөлж байна.
- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн зохицуулалтыг хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр шийдвэрлэх боломжгүй байна.
- Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Хувийн даатгалын талаар зохицуулалт хийх боломжтой боловч эрх зүйн орчин бүрэн дутмаг, баталгаатай хэрэгжих боломжгүй бөгөөд Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулалт хийх шаардлагатай юм.
- Төрөөс санхүүгийн интервенц хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм. Учир нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг шууд нэмэгдүүлэх нь сөрөг нөлөөтэй. Иймд нөхөн төлөлт хийх байдаар тусган зохицуулах нь зүйтэй.
- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. Монгол улсын Засгийн газрын тухай хуульд “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно...” гэж заасан байдаг боловч эрх зүйн орчин бүрэн хангагдаагүй байна.
- Захиргааны шийдвэр гаргах. Нийгмийн даатгалын нөхөн төлүүлэх зохицуулалт нь заавал хуулиар зохицуулах шаардлагатай бөгөөд Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулах ба захиргааны шийдвэр гаргаж шийдвэрлэх боломжгүй юм.
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай

Зорилгод хүрэх байдал: Зорилгод хүрэх байдлыг өмнө хийгдсэн судалгаа, санал асуулга, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүдийн санал зэргийг үндэслэн тодорхойллоо.

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл баталснаар малчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчин бүрдэнэ.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл баталснаар малчин нийгмийн даатгалын санд хуулийн төсөлд заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөлт хийх бөгөөд нэмэлт ажлын байр бий болгохгүй. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй болно. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл батлагдсанаар захиргааны ачаалал, зардал гарахгүй болно.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Энэхүү тандан судалгааг хийх явцад зохицуулалтын нэг л хувилбар буюу хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарыг сонгон авсан болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой үзсэн. Учир нь Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж буй учир хуулийн төсөл боловсруулах нь илүү үр өгөөжтэй нь харагдаж байна.

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар

Аргачлалын 5.5-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулах нэг хувилбарыг сонгосон ба үүнтэй холбогдуулан сонгосон нэг хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусlamж авах эрхтэй” дагуу уялдуулан боловсруулсан.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа нь Аргачлалын 6.2-т заасан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 1/-аас харагдаж байна.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Улсын төсөвт өөрчлөлт орох бөгөөд бусад захиргааны байгууллага хуулийн этгээдэд ачаалал үүсгэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 2/-оос харагдаж байна.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг үр нөлөө байхгүй ба иргэдэд эергээр нөлөөлөхөөр байна.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт-4/-аас харахад хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, зохицуулалтын хүрээнд нийцүүлэн хуулийн өөрчлөлтийн төсөл боловсруулагдсан болно. Монгол Улсын Олон улсын гэрээний нийт 674 байх бөгөөд энэхүү хуулийн өөрчлөлтийн заалтын агуулга зөрчилдөн зүйл байхгүй болно.

ТАВ. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Аргачлалын 7-д зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг харьцуулан дүгнэлт хийллээ. Үүнд:

Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл боловсруулснаар малчны Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдана.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн нийгмийн хэрэгцээ, шаардлага болон Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсч байгаа нөхцөл байдлыг сайжруулах зорилгын хүрээнд дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл нь нийгэм, эдийн засаг, цар тахлын онцгой нөлөөллөөс хамаарч тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүй малчдын эрх ашгийг хамгаалах шаардлагатай байгаа бөгөөд түүнийг хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзлээ.
2. Хуулийн төслийг зөвлөмжийн 1-т заасан хуулийн төслийг боловсруулахдаа бусад хууль тогтоомжтой нийцүүлэн хуулийн бүтэц, уялдаа болон бусад хууль тогтоомжтой нийцэж буйг харгалзан үзэх шаардлагатай.

3. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны үндэслэл, дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд “хамгийн үр дүнтэй хувилбар” буюу Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, холбогдох шатуудад хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үүгээр зөвлөж байна.

**1. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАЛТЫН СУДАЛГАА**

1.1 ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх 1.2.Оролцоог хангах	Үгүй Үгүй Үгүй Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд зохих хэмжээнд тусгана.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Малчны эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдана.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд аливаа байдлаар харшлаагүй бөгөөд хүний эрхийг хамгаалахад чиглэгдэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолтой нийцсэн эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолтой нийцсэн эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч наарт дэмжлэг болно.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Үгүй	
5.Жендерийн нэрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.

1.2 ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захирагааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захирагааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Малчны гэр бүлд хамарагдана.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	

1.3 НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас бааралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

1.4 БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохицой ашиглах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй